

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2023/03-НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Баасансүрэн  
Утас: 70362442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11-12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-21
4. Аудитын тайлан	22-26
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22-23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23-24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25-26
5. Аудитын илрүүлэлт	26-29
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	30

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Р.БАТЖАРГАЛ ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/03-НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 87.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 12.3 хувиар хэмнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 25.3 хувь буюу 554,200.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 415,736.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 40,024.4 мянган төгрөг, нормативт зардалд

2,060.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 38,037.1 мянган төгрөг, томилолтын зардалд 7,642.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 40,160.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 53,747.6 мянган төгрөг, орон нутгийн сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн албан хаагчдад 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн зардалд 21,462.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардалд 27,899.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 898,301.9 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээлд 90,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,739,262.90	1,488,902.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	975,137.80	704,095.30
33	АВЛАГА	429,036.80	187,506.30
35	БАРАА МАТЕРИАЛ	335,088.20	597,300.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,341,055.00	3,897,148.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,341,055.00	3,897,148.60
39200	Биет хөрөнгө	10,135,154.40	3,792,046.30
39300	Биет бус хөрөнгө	205,900.60	105,102.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,080,317.90	5,386,050.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	74,826.80	29,076.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	74,826.80	29,076.50
41300	Өглөг	74,826.80	29,076.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,005,491.10	5,356,974.20
51	Засгийн газрын хувь оролцоо	12,005,491.10	5,356,974.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,583,632.40	1,264,860.60
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,583,632.40	1,264,860.60
51200	Хуримтлагдсан үр дүн	5,728,476.60	2,615,475.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,693,382.10	1,476,638.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,080,317.90	5,386,050.70

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,446,228.10	2,326,319.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	447,505.00	932,259.80
110	Орлогын албан татвар	98,218.00	577,219.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	98,218.00	577,219.60
113	Хөрөнгийн албан татвар	234,581.40	217,490.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	114,705.50	137,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,183,516.70	254,567.70
120	Нийтлэг татварын бус орлого	4,183,516.70	254,567.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,815,206.40	1,139,492.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,303,912.10	1,700,982.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,303,912.10	1,700,982.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,057,789.90	1,651,650.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,150,709.80	497,562.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,830.80	60,754.70

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,429.50	415,736.30
2104	Хангамж, бараа материалын зардал	98,021.00	48,748.50
2105	Нормативт зардал	381,446.40	2,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,812.90	46,553.90
2107	Томилолт, зочны зардал	4,292.70	7,642.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,872.90	37,517.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	693,373.80	535,075.50
212	ТАТААС	93,766.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,152,356.20	49,332.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,142,316.00	625,336.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,832.50	9,932.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,052,483.50	615,404.70

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,953,258.30	-	7,953,258.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-250.8	-	-250.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,953,007.60	-	7,953,007.60
4	Тайлант үеийн үр дүн	4,052,483.50	-	4,052,483.50
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,005,491.10	-	12,005,491.10
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,005,491.10	-	12,005,491.10
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,263,921.60	-	-7,263,921.60
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,741,569.50	-	4,741,569.50
9	Тайлант үеийн үр дүн	615,404.70	-	615,404.70
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,356,974.20	-	5,356,974.20

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,499,941.40	2,422,572.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	447,505.00	932,259.80
110	Орлогын албан татвар	98,218.00	577,219.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	98,218.00	577,219.60
113	Хөрөнгийн албан татвар	234,581.40	217,490.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	114,705.50	137,550.00

1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,755.40	23,014.20
1181	Газрын төлбөр	61,386.00	92,133.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33,564.20	22,402.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	426,993.50	350,820.60
120	Нийтлэг татварын бус орлого	426,993.50	350,820.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,625,442.90	1,139,492.10
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,596,222.20	1,278,774.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,596,222.20	1,278,774.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,348,827.00	1,219,298.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,147,429.10	497,562.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,616.70	60,754.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,608.70	415,736.30
2104	Хангамж, бараа материалын зардал	89,803.60	48,948.50
2105	Нормативт зардал	301,971.90	2,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,696.20	37,443.90
2107	Томилот, зочны зардал	4,292.70	7,642.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,975.10	38,251.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,433.00	110,899.70
212	ТАТААС	93,766.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,629.20	59,475.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	903,719.20	1,143,798.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	156,810.40	1,324,841.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156,810.40	1,324,841.00
2200	Дотоод эх үүсвэрээр	156,810.40	1,324,841.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-156,810.40	-1,324,841.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-58,000.00	-90,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	58,000.00	90,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	688,908.80	-271,042.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	286,229.10	975,137.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	975,137.80	704,095.30

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,496,774,200.00</b>	<b>2,189,273,672.14</b>	<b>307,500,527.86</b>	87.68
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,277,960,800.00</b>	<b>1,200,971,750.34</b>	<b>76,989,049.66</b>	93.98
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,223,844,400.00</b>	<b>1,151,609,351.34</b>	<b>72,235,048.66</b>	94.10
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>516,597,200.00</b>	<b>493,614,152.92</b>	<b>22,983,047.08</b>	95.55
210101	Үндсэн цалин	256,188,200.00	248,519,321.40	<b>7,668,878.60</b>	97.01
210102	Нэмэгдэл	73,233,300.00	72,867,345.17	<b>365,954.83</b>	99.50
210104	Урамшуулал	0	1,780,869.36	<b>-1,780,869.36</b>	
210105	Гэрээт ажлын хөлс	187,175,700.00	170,446,616.99	<b>16,729,083.01</b>	91.06
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,329,700.00</b>	<b>60,586,693.41</b>	<b>3,743,006.59</b>	94.18
210201	Тэтгэврийн даатгал	44,077,100.00	42,081,490.60	<b>1,995,609.40</b>	95.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,086,700.00	4,839,650.91	<b>247,049.09</b>	95.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,069,400.00	3,876,721.24	<b>192,678.76</b>	95.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,008,700.00	889,005.10	<b>119,694.90</b>	88.13
210205	Эрүүл мэндийн даатгал	10,087,800.00	8,899,825.56	<b>1,187,974.44</b>	88.22
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>427,975,100.00</b>	<b>415,736,287.24</b>	<b>12,238,812.76</b>	97.14
210301	Гэрэл, цахилгаан	47,363,000.00	38,425,556.46	<b>8,937,443.54</b>	81.13
210302	Түлш, халаалт	367,895,800.00	366,554,330.78	<b>1,341,469.22</b>	99.64
210303	Цэвэр, бохир ус	12,716,300.00	10,756,400.00	<b>1,959,900.00</b>	84.59
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,888,900.00</b>	<b>40,024,360.49</b>	<b>1,864,539.51</b>	95.55
210401	Бичиг хэрэг	4,498,800.00	4,654,220.00	<b>-155,420.00</b>	103.45
210402	Тээвэр, шатахуун	21,600,000.00	19,767,201.00	<b>1,832,799.00</b>	91.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,436,100.00	3,250,054.49	<b>186,045.51</b>	94.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	10,023,185.00	<b>-23,185.00</b>	100.23
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,354,000.00	2,329,700.00	<b>24,300.00</b>	98.97
2105	<b>Нормативт зардал</b>	<b>2,200,000.00</b>	<b>2,060,000.00</b>	<b>140,000.00</b>	93.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,200,000.00	2,060,000.00	<b>140,000.00</b>	93.64
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,429,100.00</b>	<b>38,037,100.00</b>	<b>1,392,000.00</b>	96.47
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,672,200.00	7,540,000.00	<b>132,200.00</b>	98.28
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	648,500.00	620,000.00	<b>28,500.00</b>	95.61
210604	Урсгал засвар	31,108,400.00	29,877,100.00	<b>1,231,300.00</b>	96.04
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,769,400.00</b>	<b>7,642,400.00</b>	<b>1,127,000.00</b>	87.15
210702	Дотоод албан томилолт	8,769,400.00	7,642,400.00	<b>1,127,000.00</b>	87.15
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>61,953,000.00</b>	<b>40,160,686.28</b>	<b>21,792,313.72</b>	64.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,312,400.00	38,889,386.28	<b>20,423,013.72</b>	65.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	745,000.00	0	<b>745,000.00</b>	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,200.00	108,900.00	<b>440,300.00</b>	19.83

210804	Тээврийн хэрэгслийн татвар	311,700.00	234,000.00	77,700.00	75.07
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	96,500.00	90,600.00	5,900.00	93.89
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	521,900.00	500,000.00	21,900.00	95.80
210807	Газрын төлбөр	108,000.00	108,000.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,200.00	0	2,200.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	306,100.00	229,800.00	76,300.00	75.07
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,702,000.00</b>	<b>53,747,671.00</b>	<b>6,954,329.00</b>	88.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,202,000.00	48,639,271.00	6,562,729.00	88.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	5,108,400.00	391,600.00	92.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,116,400.00</b>	<b>49,362,399.00</b>	<b>4,754,001.00</b>	91.22
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,116,400.00</b>	<b>49,362,399.00</b>	<b>4,754,001.00</b>	91.22
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,356,400.00	21,462,534.00	1,893,866.00	91.89
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,760,000.00	27,899,865.00	2,860,135.00	90.70
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,062,313,400.00</b>	<b>898,301,921.80</b>	<b>164,011,478.20</b>	84.56
220001	Барилга байгууламж	1,047,313,400.00	890,801,921.80	156,511,478.20	85.06
223001	Бусад хөрөнгө	15,000,000.00	7,500,000.00	7,500,000.00	50.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>156,500,000.00</b>	<b>90,000,000.00</b>	<b>66,500,000.00</b>	57.51
230001	Эргэж төлөгдөх зээл	156,500,000.00	90,000,000.00	66,500,000.00	57.51
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,496,774,200.00</b>	<b>2,072,692,821.34</b>	<b>424,081,378.66</b>	83.01
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,070,424,200.00</b>	<b>1,952,623,950.34</b>	<b>117,800,249.66</b>	94.31
320001	Орон нутгийн төсвөөс	1,568,460,800.00	1,450,660,550.34	117,800,249.66	92.49
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	501,963,400.00	501,963,400.00	0.00	100.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>426,350,000.00</b>	<b>120,068,871.00</b>	<b>306,281,129.00</b>	28.16
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	114,229,871.00	-114,229,871.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,839,000.00	-839,000.00	116.78
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	421,350,000.00	0.00	421,350,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	427,120,053.75	-427,120,053.75	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	306,281,871.90	-306,281,871.90	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>531,538,753.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>121,519,313.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>84,208,940.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,948,000.00</b>
210101	Үндсэн цалин	3,637,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	310,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>168,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	114,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,440.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,752.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,688.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,880.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,924,171.00</b>
210401	Бичиг хэрэг	785,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,089,171.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,516,760.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,516,760.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,500,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,152,009.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,152,009.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>37,310,373.73</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>37,310,373.73</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	31,454,674.80
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,855,698.93
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>410,019,440.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>410,019,440.00</b>
220001	Барилга байгууламж	410,019,440.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>525,683,054.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>525,683,054.80</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,836,571.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	468,306,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,539,583.80
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-5,855,698.93</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,855,698.93

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Баянгол сумын ТТЗ гэх/-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжин иргэн, өрх бүрийг ажил орлоготой байлгах боломжийг хамтын хичээл зүтгэлээр бүрдүүлж, эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай иргэн төвтэй бүсийн загвар сум болох.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төр иргэний харилцан итгэлцлийг хангасан чадварлаг засаглалын бодлогыг хэрэгжүүлэх,
- Иргэн бүрийг хөдөлмөрлөх ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулах,
- Орон нутгийн түүхий эдийн бааз суурь дээр тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”, 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянгол сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянгол сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,694,267.2 мянган төгрөгөөр буюу 55.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	975,137.8	704,095.3	(271,042.5)
Авлага	429,036.8	187,506.3	(241,530.5)
Бараа материал	335,088.3	597,300.5	262,212.2
Үндсэн хөрөнгө	10,341,055.0	3,897,148.6	(6,443,906.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,080,317.9</b>	<b>5,386,050.7</b>	<b>(6,694,267.2)</b>
Өр төлбөр	74,826.8	29,076.5	(45,750.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,005,491.1	5,356,974.2	(6,648,516.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>12,080,317.9</b>	<b>5,386,050.7</b>	<b>(6,694,267.2)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад гарсан өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 704,095.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 271,042.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	975,137.8	704,095.3	(271,042.5)
Төгрөг	975,137.8	704,095.3	(271,042.5)
Төрийн сангийн харилцах	975,137.8	704,095.3	(271,042.5)
Арилжааны банк дахь харилцах			
<b>Дүн</b>	<b>975,137.8</b>	<b>704,095.3</b>	<b>(271,042.5)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 370,162.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 133,878.6 мянган төгрөг, ХХС-ийн үлдэгдэл 172,403.2 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 27,650.6 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 187,506.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 241,530.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	193,541.3	90,000.0	(103,541.3)
Хувь хүмүүсээс авах авлага	235,495.5	97,506.3	(137,989.2)
<b>Дүн</b>	<b>429,036.8</b>	<b>187,506.3</b>	<b>(241,530.5)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 187,506.3 мянган төгрөг болж 241,530.5 мянган төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр эрүүл мэндийн төв нь ЭМЯ-ны харьяанд шилжиж /сумын Эрүүл мэндийн төвийн 193,541.3 мянган төгрөгийн авлага/-авлага шилжсэнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдэлд ХХС-аас олгосон зээлийн 183,878.7 мянган төгрөг, зээлийн хүүгийн 3,627.5 мянган төгрөг зэрэг нийт 187,506.3 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

Тайлант онд насжилт өндөртэй /3-аас дээш жил/ ХХС-ийн зээлийн авлагыг барагдуулахаар 5 иргэнтэй холбоотой 42,207.9 мянган төгрөгийн нэхэмжлэлийг холбогдох шатны шүүхэд хүргүүлсэн бөгөөд Шүүхийн шийдвэрийн дагуу 2 иргэнээс 13,101.2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах боломжтой болсон байна. / Шүүхийн шийдвэрийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03, 23-нд зээл, хүүгийн авлагыг бүрэн барагдуулсан./

#### Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд ХХС-аас Хүүгийн хишиг ХХК, Хараагийн баян үрс хоршоодод олгосон нийт 90,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 597,300.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 262,212.3 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>13,910.5</b>	-	<b>(13,910.5)</b>
Тусгай зориулалттай материал	2,390.0	-	(2,390.0)
Эм боох материал	11,520.5	-	(11,520.5)
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>18,000.0</b>	-	<b>(18,000.0)</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>30,535.8</b>	<b>5,980.6</b>	<b>(24,555.2)</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>272,641.9</b>	<b>496,319.9</b>	<b>223,677.9</b>
Бичиг хэргийн материал	5,308.4	2,293.5	(3,014.9)
Аж ахуйн материал	6,773.1	2,359.5	(4,413.6)
Түлш, шатах тослох материал	23.9	-	(23.9)
Хүнсний материал	5,573.2	-	(5,573.2)
Бусад хангамжийн материал	254,963.3	491,666.9	236,703.5
<b>Мал амьтад</b>	-	<b>95,000.0</b>	<b>95,000.0</b>
<b>Дүн</b>	<b>335,088.2</b>	<b>597,300.5</b>	<b>262,212.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 262,212.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,316,262.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 113,180.0 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авсан болон 116,118.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, үнэ төлбөргүйгээр 779,924.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт /сургууль, цэцэрлэг, ЭМТ/ байгууллагуудын 271,187.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 290,024.9 мянган төгрөгийн “Сумын ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл, 100 тн-н багтаамжтай зoorь, цэвэрлэх байгууламжийн зураг, төсөв”-ийг бусад хангамжийн материалын дансанд, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 95,000.0 мянган төгрөгийн эцэг мал /бух, төлгөн хуц, хурган хуц гэх мэт/ худалдан авч мал амьтад дансанд орлогоор тус тус бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь 2,941.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй байна.

**3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл анхны өртгөөр 5,555,225.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,043,631.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>12,389,671.7</b>	<b>5,447,469.6</b>	<b>(6,942,202.1)</b>
Барилга, байгууламж, орон сууц	8,826,973.3	3,215,807.4	(5,611,165.9)
Авто-тээврийн хэрэгсэл	339,110.5	154,658.9	(184,451.6)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,065,906.3	449,088.5	(616,817.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	591,678.1	106,094.3	(485,583.8)
Зам, гүүрийн байгууламж	951,408.2	951,408.2	-
Бусад үндсэн хөрөнгө	531,164.4	450,417.8	(80,746.6)
Дуусаагүй барилга, байгууламж	-	119,994.5	119,994.5
Ном	83,430.9	-	(83,430.9)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>209,185.0</b>	<b>107,755.4</b>	<b>(101,429.6)</b>
Программ хангамж	8,300.0	4,200.0	(4,100.0)
Бусад биет бус хөрөнгө	200,885.0	103,555.4	(97,329.6)
<b>Дүн</b>	<b>12,598,856.7</b>	<b>5,555,225.0</b>	<b>(7,043,631.7)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 7,043,631.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 136,514.1 мянган төгрөгийн тоног

төхөөрөмж худалдан авсан, үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан 676,727.5 мянган төгрөг / Аймгийн БТСГ-ын урсгал засварын зардлын санхүүжилтээр Спорт цогцолборын барилгад 19,915.5 мянган төгрөгийн засвар хийгдсэн, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн нийт 656,812.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хүүхдийн тоглоомын талбай, цамхагт гэрэлтүүлэг, гүний худаг, мал угаалгын ванн гэх мэт./ зэрэг нийт 813,241.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагуудын 7,815,525.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 41,347.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 29,076.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 45,750.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	23,929.6	-	(23,929.6)
Байгууллагад төлөх өглөг	49,749.0	27,650.6	(22,098.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	1,148.2	1,425.9	277.7
<b>Дүн</b>	<b>74,826.8</b>	<b>29,076.5</b>	<b>(45,750.3)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллага болох сумын ЭМТ-ийн 23,929.6 мянган төгрөгийн өр төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээний барьцааны 27,650.6 мянган төгрөгийн, ХХС-аас хувь хүмүүст төлөх 1,148.2 мянган төгрөгийн, орон нутгийн ерөнхий орлогын дансны 277.7 мянган төгрөг /нэр данс зөрүүтэйгээс буцаж орсон/-ийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант онд орон нутгийн ерөнхий орлогын дансны 277.7 мянган төгрөг /нэр данс зөрүүтэйгээс буцаж шилжүүлсэн/-ийн өр төлбөр шинээр үүссэн байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,356,974.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,648,516.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,583,632.4	1,264,860.6	(1,318,771.8)
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,728,476.6</b>	<b>2,615,475.6</b>	<b>(3,113,001.0)</b>
Өмнөх үеийн үр дүн	1,675,993.1	2,000,070.8	
Тайлант үеийн үр дүн	4,052,483.5	615,404.8	

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,693,382.1	1,476,638.0	(2,216,744.1)
<b>Дүн</b>	<b>12,005,491.1</b>	<b>5,356,974.2</b>	<b>(6,648,516.9)</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,356,974.2 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.7 Зардлын данс

Тайлант онд зардлын данстай холбоотой нийт **16,985.3** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

#### Сумын ИТХ нь:

- Орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнд сумын ИТХ-ын даргын албан тушаалаас чөлөөлөгдсөн Р.Батжаргалд эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг албан тушаалын буюу үндсэн цалингаас бус нийт бодогдсон цалингаас тооцож 1,892.2 мянган төгрөг илүү олгосон,
- Тухайн сард ажилласан нийт ажлын цагийн 10 хувиар бус 40 цаг илүү ажилласнаар тооцож 2 албан хаагчид нийт 474.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл илүү олгосон,

- Сумын ИТХ нь нутгийн удирдлагын байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүндэтгэлийн хуралдаанд оролцогчдод нийт 6,604.0 мянган төгрөгийн,

#### Сумын ЗДТГ нь:

- Албан хаагчдад тухайн сард ажилласан нийт ажлын цагийн 10 хувиар бус 24-72 цаг илүү ажилласнаар тооцож нийт 3,604.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл илүү олгосон,
- Сумын Засаг даргын 2022 оны Б/42 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-ны гишүүнээр ажилласан гэх үндэслэлээр сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Золзаяаг 450.0 мянган төгрөгөөр, О.Мөнх-Одыг 270.0 мянган төгрөгөөр, А.Болормааг 90.0 мянган төгрөгөөр тус тус шагнасан,
- Сумын Засаг даргын 2022 оны Б/36 дугаар захирамжаар сумын орлогч дарга, болон төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарыг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажилласан гэх үндэслэлээр тус бүр 450.0 мянган төгрөгөөр буюу нийт 3,600.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг ЗДНХ-өөс олгосон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт**

Баянгол сумын ИТХ-ын “2022 оны төсөвт тодотгол оруулах тухай” 51 дүгээр тогтоолоор 919,830.0 мянган төгрөгийн татварын орлого, 177,340.0 мянган СЭА-2023/03-НА-СТА-ТТЗ

төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,158,393.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>919,830.0</b>	<b>932,259.8</b>	<b>12,429.8</b>	<b>101.4</b>
Хувь хүний орлогын албан татвар	501,000.0	448,633.4	(52,366.6)	89.5
Үйл ажиллагааны орлогын албан татвар	43,300.0	77,831.5	34,531.5	179.7
Хөрөнгийн орлого	10,000.0	35,152.3	25,152.3	351.5
Хөрөнгө борлуулсны орлого	15,000.0	15,602.3	602.3	104.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	150,000.0	96,622.1	(53,377.9)	64.4
Малын тоо толгойн албан татвар	100,000.0	118,888.2	18,888.2	118.9
Бууны албан татвар	1,300.0	1,980.0	680.0	152.3
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	2,655.9	(3,344.1)	44.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	2,309.0	1,809.0	461.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,000.0	18,049.3	6,049.0	150.4
Газрын төлбөр	64,715.9	79,933.5	15,217.6	123.5
Газрын дуудлага худалдааны орлого	5,432.0	12,199.5	6,767.5	224.6
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	130.1	1,360.7	1,230.6	10.4 дах
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	452.0	-	(452.0)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.0	21,042.1	11,042.1	210.4
<b>Татварын бус орлого</b>	<b>177,340.0</b>	<b>226,134.0</b>	<b>48,794.0</b>	<b>127.5</b>
Хүү, торгуулийн орлого	132,340.0	154,152.3	21,812.3	116.5
Бусад орлого	40,000.0	71,981.7	31,981.7	179.9
<b>Нийт дүн</b>	<b>1,097,170.0</b>	<b>1,158,393.8</b>	<b>61,223.8</b>	<b>105.5</b>

Эх сурвалж: Баянгол сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үйл ажиллагааны орлогын албан татвар 34,531.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 25,152.3 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны албан татвар 602.3 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 18,888.2 мянган төгрөгөөр, бууны албан татвар 680.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 1,809.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 6,049.0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 15,217.6 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 6,767.5 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 1,230.6 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 11,042.1 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 21,812.3 мянган төгрөгөөр, бусад орлого 31,981.7 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Хувь хүний орлогын албан татвар 52,366.6 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 53,377.9 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 3,344.1 мянган төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 452.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Давж биелсэн орлогууд:**

- ✓ **Үйл ажиллагааны орлогын албан татвар:** ХХААХҮ-ийн яамнаас сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд урамшуулал олгосонтой холбоотой,
- ✓ **Хөрөнгийн орлого:** Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого өссөнтэй холбоотой,
- ✓ **Түгээмэл тархацтай ашигт малтмал:** Суманд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой хайрга, дайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт ихэссэнтэй холбоотой,
- ✓ **Газрын дуудлага худалдаа:** Иргэдийн газар эзэмших хэрэгцээ ихэссэн, газрын дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулснаар иргэдийн оролцоо нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Байгалийн ургамал ашигласны төлбөр:** Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр:** Зэргэлдээх сумдаас түлээний мод худалдан авсан иргэдэд төлбөр ногдуулсантай холбоотой,
- ✓ **Бусад орлого:** “Тод-Ундарга” ХХК-иас 43,473.5 мянган төгрөгийн газар эзэмших эрхийн хураамж төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

#### **Тасарсан орлогууд:**

- ✓ **Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогын албан татвар:** Өмнөх оны татварын орлогыг аймгийн татварын орлогод төвлөрүүлсэнтэй холбоотой,
- ✓ **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:** Татварын орлогын төлөвлөгөөг өндөр тогтоосноос шалтгаалсан,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** E-mongol цахим системээс авч байгаа аливаа лавлагаа, мэдээлэлд нотариат хийлгэх шаардлагагүй болсонтой холбоотой,
- ✓ **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** Тайлант онд ан амьтан агнах зөвшөөрөл олгогдоогүйтэй холбоотой төлөвлөгөө тасарсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,322,259.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 33 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,092,170.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 220,341.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 501,963.4 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 324,177.7 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 260,350.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 5,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,404,002.1** мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ны 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлого 1,092,170.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 338,006.7 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 138,284.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 501,963.4 мянган төгрөг, сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 260,350.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 161,000.0 мянган төгрөг зэрэг нийт **2,496,774.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулахаар эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 1,158,393.8 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 5,839.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 492,413.1 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг 138,284.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн шилжүүлэг 501,963.4 мянган төгрөг, сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл 274,188.9 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны үлдэгдэл 148,673.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн 114,229.9 мянган төгрөг зэрэг нийт **2,833,985.9** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,189,273.7** мянган төгрөг буюу 87.7 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 22,983.1 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 3,743.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,238.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1,864.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 140.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,392.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,127.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 21,792.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 6,954.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 4,754.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 164,011.5 мянган төгрөгөөр, эргэн төлөгдөх зээл 66,500.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 7 төсөл, арга хэмжээнд 1,062,313.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 898,301.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 133,878.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээг аймгийн комиссын актаар ашиглалтад оруулах ажил оройтож он дамжсанаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 462,574.3 мянган төгрөг, сумын ЗДНХ-өөс 6,836.6 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 5,732.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 50,539.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 5,855.7 мянган төгрөг зэрэг нийт **531,538.8** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 3,948.0 мянган төгрөг, ажил олгогчийн НДШ-ийн зардалд 168.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 8,924.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал зардалд 8,516.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 5,500.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 57,152.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 37,310.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 410,019.4 мянган төгрөг зэрэг нийт **531,538.8** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянгол сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ХХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон, санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4,305,285.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 43,052.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв зэрэг байгууллагууд нь тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 1,700,982.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **25,514.7** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах,

батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, ЗДНХ-ийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэл хүргүүлсний дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар жилийн эцэст батлагдсан төсвийг 12.3 хувиар хэмнэсэн,
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудыг авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажилласан,
- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн 5 зээлдэгчийн авлагыг барагдуулах чиглэлээр шүүхэд нэхэмжлэх гарган ажилласнаар хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийг төлүүлэх боломжийг нэмэгдүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт **11,014.0** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Сумын ИТХ нь нутгийн удирдлагын байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүндэтгэлийн хуралдаанд оролцогчдод нийт 6,604.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, зарцуулсан,
- Сумын Засаг даргын 2022 оны Б/42 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-ны гишүүнээр ажилласан гэх үндэслэлээр сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Золзаяаг 450.0 мянган төгрөгөөр, О.Мөнх-Одыг 270.0 мянган төгрөгөөр, А.Болормааг 90.0 мянган төгрөгөөр тус тус шагнасан,
- Сумын Засаг даргын 2022 оны Б/36 дугаар захирамжаар сумын Засаг даргын орлогч дарга, Санхүүгийн албаны дарга болон төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч зэрэг 8 хүнийг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажилласан гэх үндэслэлээр нийт 3,600.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг ЗДНХ-өөс олгосон байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	86	69	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	151	79	72	-
3	Засаг даргын Тамгын газар	151	63	88	-
	<b>Нийт дүн</b>	<b>457</b>	<b>228</b>	<b>229</b>	<b>-</b>

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 457 мэдээллээс 228 мэдээллийг хугацаанд нь, 229 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тус сумын ИТХ нь зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй 3 төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталж, батлагдсан төсөвт багтааж худалдан авах ажиллагаа зохион байгуулж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1 дэх “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг СЭА-2023/03-НА-СТА-ТТЗ

хэрэгжүүлнэ. Үүнд:” 3.1.3. “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтад зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдсэн төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,210.0 мянган төгрөгийн албан шаардлага, 22,849.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 157,671.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 85.7 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	6,210.0	1	6,210.0	100.0
Зөвлөмж	6	180,520.0	5	22,849.0	83.3
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>186,730.0</b>	<b>6</b>	<b>29,059.0</b>	<b>85.7</b>

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг сумын ЗДТГ хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг

хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр сумын Санхүүгийн албаны даргад үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэрийг үндэслэн 1,248.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **109,926.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,971.3 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,955.3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 90,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

#### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнд сумын ИТХ-ын даргын албан тушаалаас чөлөөлөгдсөн Р.Батжаргалд эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг албан тушаалын буюу үндсэн цалингаас бус нийт бодогдсон цалингаас тооцож 1,892.2 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх “*Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн тэтгэмжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1.2** Албан хаагчдад тухайн сард ажилласан нийт ажлын цагийн 10 хувиар бус тус бүр 24-72 цаг илүү ажилласнаар тооцож сумын ИТХ нь 474.6 мянган төгрөгийн, ЗДТГ нь 3,604.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг тус тус илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3 дахь “Илүү цагаар, долоо хоногийн амралтын

өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн **10 хувиас хэтрэхгүй байна**. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь **16-аас илүүгүй байна**.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

**5.2.1** Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нийт **11,014.0** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сумын ИТХ нь нутгийн удирдлагын байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүндэтгэлийн хуралдаанд оролцогчдод нийт 6,604.0 мянган төгрөгийн, бэлэг дурсгалын зүйлсийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, зарцуулсан,
2. Сумын Засаг даргын 2022 оны Б/42 дугаар захирамжаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-ны гишүүнээр ажилласан гэх үндэслэлээр сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Золзаяаг 450.0 мянган төгрөгөөр, О.Мөнх-Одыг 270.0 мянган төгрөгөөр, А.Болормааг 90.0 мянган төгрөгөөр тус тус шагнасан,
3. Сумын Засаг даргын 2022 оны Б/36 дугаар захирамжаар сумын Засаг даргын орлогч дарга, Санхүүгийн албаны дарга болон төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч зэрэг 8 хүнийг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажилласан гэх үндэслэлээр нийт 3,600.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг ЗДНХ-өөс олгосон байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж, хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр шагнал, урамшуулал олгохгүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.** Сумын ЗДТГ нь өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 2,941.3 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр,

тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хоршоог хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд ХХС-аас Хүүгийн хишиг ХХК-д олгосон 60,000.0 мянган төгрөгийн, Хараагийн баян үрс хоршоонд олгосон 30,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.4 дэх “Энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХС-аас олгож байгаа зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэлэх ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр олгож байх.

#### **2. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	1						1					
Сумын ИТХ	2	8,970.8	1	2,366.8	1	6,604.0						
Сумын ЗДТГ	2	10,955.8	1	3,604.5	1	7,351.3						
ХХС	1	90,000.0					1	90,000.0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>109,926.6</b>	<b>2</b>	<b>5,971.3</b>	<b>2</b>	<b>13,955.3</b>	<b>2</b>	<b>90,000.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	69	-			69	-		
ИТХ	72	-			72	-		
ЗДТГ	88	-			88	-		
<b>Дүн</b>	<b>229</b>	<b>-</b>			<b>229</b>	<b>-</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ОНХС	1				1			
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			
<b>Нийт дүн</b>	<b>230</b>				<b>230</b>			